



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠑᠑ оны ᠐ᠪ сарын 14 өдөр

Дугаар А/1167

Мандалговь

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
эрүүл мэнд, боловсрол, нийгмийн
хамгааллын аймгийн салбар комисс
өөрчлөн байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1, 42 дугаар зүйлийн 42.1.1, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн "Дүрэм шинэчлэн батлах тухай" 173 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймгийн салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй өөрчлөн байгуулсугай.

- Дарга: -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд: -Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн их эмч
-Нэгдсэн эмнэлгийн сэтгэц, мэдрэлийн их эмч
-Боловсрол шинжлэх ухааны газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн
-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн
-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга: С.Гарамханд (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Салбар хорооны үйл ажиллагааг бэхжүүлэн, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг шинэ шатанд гарган үр дүнтэй ажиллахыг салбар комиссын даргад үүрэг болгосугай.

3. Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/92 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

4822100408